

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Аялал жуулчлалын газарт эхний хагас жилийн байдлаар нийт 11 өргөдөл, гомдол, хүсэлт ирсний 10-ыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Өргөдөл, гомдлын тайланг дэлгэрэнгүй авч үзвэл:

- Хугацаандаа шийдвэрлэсэн: 10
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн: 1 гэсэн үзүүлэлттэй байна.

Үүнээс:

- Гомдол: 1
- Хүсэлт: 9
- Санал: 1

Өргөдөл, гомдлыг хандалтын хувьд авч үзвэл:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Ажлаас чөлөөлөгдөх тухай	1	10%
2	Хүүхэд асрах чөлөө хүсэх тухай	1	10%
3	Ажилд орох тухай	1	10%
4	Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагааны тухай	8	70 %
Нийт өргөдөл, гомдлын дүн		11	100%

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хугацааны хувьд авч үзвэл:

2020 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног 21 цаг 11 минут байна. Энэ хугацаанд тус газар хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг иргэд болон аж ахуйн нэгжүүдэд хариуг албан бичиг болон утсаар мэдэгдэж 100% барагдуулав.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар газрын дарга болон захиргааны хэлтсийн даргад тухай бүр танилцуулан ажиллаж байна. Өргөдөл гомдлын тайланг газрын хурлаар танилцуулж, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал бүр хугацаанд нь хүргүүлж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг зөрчлийн хувьд авч үзвэл:

2020 оны хагас жилийн байдлаар нийт 9 зөрчил гарсан байна. Үүнд:

- Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчлийн тоо: 7
- Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо: 2 гэсэн үзүүлэлттэй байна.
- Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 1 өргөдлийг гаргасан албан хаагчид газрын хурал дээр мэдэгдэх хуудас өгч, egr.ulaanbaatar.mn албан хэрэг хөтлөлтийн програмыг ашиглах заавар, зөвөлгөөг өгч, тогтмол шалгаж байхыг анхааруулав.

Зөрчил гаргасан албан хаагчдад тухай бүр сануулж сар бүр газрын болон хэлтсийн даргад танилцуулж зохих арга хэмжээг авч ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



С.БАТБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

M. Muryu.

Т.ТУУЛ